



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 28 дөр


Дугаар А/113

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нийслэлийн нутаг дэвсгэрт хийгдэх тохижилтын ажлын судалгааг хийх, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшил ашиглалтын байдал, тохижилтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих зөвлөх үйлчилгээний 19/06-132 гэрээт ажлыг гэрээний дагуу гүйцэтгэлээр санхүүжүүлэх 50000000 /тавин сая/ төгрөгийг хот тохижилтын бусад арга хэмжээний зардлын захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

